



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/145/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЧУЛУУТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ЛОНЖИДПИЛМАА ТАНАА

᠔᠔᠒.᠐᠔.᠒᠒ № 44

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг..

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,285,900.20</u>	<u>89,873,344.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	78,285,900.20	89,873,344.09
351	Түүхий эд материал	841,000.00	2,308,000.00
35130	Эм боох материал	841,000.00	2,308,000.00
354	Хангамжийн материал	77,444,900.20	87,565,344.09
35410	Бичиг хэргийн материал	518,000.00	1,711,599.09
35420	Аж ахуйн материал	76,146,900.20	84,970,737.20
35440	Түлш, шатах тослох материал	750,000.00	522,000.00
35450	Барилгын засварын материал	30,000.00	-
35460	Хүнсний материал	-	361,007.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>791,076,738.14</u>	<u>868,654,991.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	791,076,738.14	868,654,991.50
392	Биет хөрөнгө	713,298,404.81	792,003,324.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	615,118,546.00	615,118,546.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	21,484,111.80	32,226,598.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	1,680,000.00	5,040,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,733,682.83	168,967,720.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	109,713,327.38	116,474,913.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	139,075,620.36	213,309,345.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	100,956,529.41	114,824,299.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,005,900.00	1,005,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	1,005,900.00	1,005,900.00
39217	Ном	28,604,524.21	29,573,524.21
393	Биет бус хөрөнгө	77,778,333.33	76,651,666.63
39301	Програм хангамж	7,495,000.00	7,495,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	616,666.67	1,743,333.37
39303	Бусад биет бус хөрөнгө	70,900,000.00	70,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>869,362,638.34</u>	<u>958,528,335.59</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>494,606.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	494,606.00
413	Өглөг	-	494,606.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	494,606.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>869,362,638.34</u>	<u>958,033,729.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	869,362,638.34	958,033,729.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	506,696,493.87	506,696,493.87
51101	Өмч: - төрийн	506,696,493.87	506,696,493.87
512	Хуримтлагдсан үр дүн	205,880,229.24	117,209,137.99
51210	Өмнөх үеийн үр дүн	205,880,229.24	205,880,229.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	88,671,091.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	568,546,373.71	568,546,373.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>869,362,638.34</u>	<u>958,528,335.59</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,020,230,663.20	975,406,549.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,453,563.20	-
120	Нийтлэг татварын бус орлого	43,453,563.20	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,453,563.20	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,453,563.20	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	976,777,100.00	975,406,549.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	923,512,500.00	922,995,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	923,512,500.00	922,995,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	743,400.00	8,648,249.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	648,249.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	743,400.00	8,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,521,200.00	43,763,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,521,200.00	43,763,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,019,578,771.45	998,022,970.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,019,578,771.45	998,022,970.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,197,536.26	965,555,836.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	729,053,483.00	731,264,531.00
210101	Үндсэн цалин	505,289,967.00	526,036,870.00
210102	Нэмэгдэл	164,401,284.00	147,851,735.00
210104	Урамшуулал	59,362,232.00	57,375,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,775,147.61	95,250,407.00
210201	Тэтгэврийн даатгал	64,424,642.59	70,229,412.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,435,742.85	6,374,323.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,508,920.72	4,972,859.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,032,160.17	1,242,864.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,373,681.28	12,430,949.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,633,200.00	44,485,906.00
210301	Гэрэл, цахилгаан	10,117,806.00	10,848,856.00
210302	Түлш, халаалт	33,515,394.00	33,587,050.00
210303	Цэвэр, бохир ус	-	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,922,156.00	10,723,494.00
210401	Бичиг хэрэг	10,002,295.00	1,152,750.00
210402	Тээвэр, шатахуун	5,810,000.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	656,100.00	305,600.00
210404	Ном, хэвлэл	52,000.00	74,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	362,166.00	185,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,039,595.00	5,005,244.00
2105	Нормативт зардал	12,945,554.20	36,089,370.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,427,100.00	12,007,150.00
210502	Хоол, хүнс	8,672,154.20	23,950,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,846,300.00	132,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,038,200.00	1,085,169.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	346,769.00
210604	Урсгал засвар	5,038,200.00	738,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,223,000.00	2,333,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,791,000.00	1,533,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,156,795.45	44,323,409.62

Архангай аймгийн Чулуунт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,452,500.00	8,464,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,704,295.45	35,858,509.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,381,235.19	32,467,134.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,266,375.80	26,808,855.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,998,275.80	25,258,855.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,100.00	1,550,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,114,859.39	5,658,279.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,114,859.39	5,658,279.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>651,891.75</u>	<u>-</u>
			<u>22,616,421.73</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>651,891.75</u>	<u>-</u>
			<u>22,616,421.73</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 206,532,120.99	868,710,746.59
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 206,532,120.99	868,710,746.59
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	651,891.75	651,891.75
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 205,880,229.24	869,362,638.34
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 205,880,229.24	869,362,638.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 205,880,229.24	869,362,638.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	88,671,091.25	88,671,091.25
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	506,696,493.87	568,546,373.71	- 117,209,137.99	958,033,729.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	976,777,100.00	975,406,549.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	976,777,100.00	975,406,549.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	923,512,500.00	922,995,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	923,512,500.00	922,995,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	743,400.00	8,648,249.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	648,249.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	743,400.00	8,000,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,521,200.00	43,763,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,521,200.00	43,763,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	969,427,100.00	971,917,549.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	969,427,100.00	971,917,549.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	931,833,230.61	939,373,487.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,535,500.00	731,158,400.00
210101	Үндсэн цалин	504,771,984.00	526,646,549.00
210102	Нэмэгдэл	164,401,284.00	147,135,925.00
210104	Урамшуулал	59,362,232.00	57,375,926.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,293,130.61	95,356,538.00
210201	Тэтгэврийн даатгал	64,424,642.59	70,335,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,953,725.85	6,374,323.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,508,920.72	4,972,859.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,032,160.17	1,242,864.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,373,681.28	12,430,947.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,383,200.00	43,763,300.00
210301	Гэрэл, цахилгаан	10,117,806.00	10,848,856.00
210302	Түлш, халаалт	34,265,394.00	32,864,444.00
210303	Цэвэр, бохир ус	-	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,976,700.00	8,502,949.09
210401	Бичиг хэрэг	1,631,500.00	1,217,249.09
210402	Тээвэр, шатахуун	5,810,000.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	871,000.00	492,200.00
210404	Ном, хэвлэл	405,400.00	281,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	408,700.00	191,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,850,100.00	2,321,100.00
2105	Норматив зардал	38,637,300.00	43,046,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,268,100.00	14,592,200.00
210502	Хоол, хүнс	32,977,900.00	24,234,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,391,300.00	4,220,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,498,000.00	9,898,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,066,000.00	9,098,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,077,400.00	7,647,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,077,400.00	7,647,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,593,869.39	32,544,062.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,479,010.00	26,885,783.00

Архангай аймгийн Чулуунт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,211,010.00	25,335,783.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,268,000.00	1,550,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,114,859.39	5,658,279.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,114,859.39	5,658,279.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,350,000.00</u>	<u>3,489,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,350,000.00	3,489,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,350,000.00	3,489,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,350,000.00	3,489,000.00
223001	Бусад хөрөнгө	7,350,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,489,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>7,350,000.00</u>	<u>3,489,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	966,758,300.00	961,100,021.00	5,658,279.00	99.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,758,300.00	961,100,021.00	5,658,279.00	99.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,209,900.00	934,214,238.00	2,995,662.00	99.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,158,400.00	731,158,400.00	-	100.00
210101	Үндсэн цалин	522,895,200.00	526,646,549.00	- 3,751,349.00	100.72
210102	Нэмэгдэл	144,915,100.00	147,135,925.00	- 2,220,825.00	101.53
210104	Урамшуулал	63,348,100.00	57,375,926.00	5,972,174.00	90.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,352,200.00	95,356,538.00	2,995,662.00	96.95
210201	Тэтгэврийн даатгал	71,548,900.00	70,335,545.00	1,213,355.00	98.30
210202	Тэтгэмжийн даатгал	6,700,800.00	6,374,323.00	326,477.00	95.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,360,700.00	4,972,859.00	387,841.00	92.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,340,100.00	1,242,864.00	97,236.00	92.74
210205	Эрүүл мэндийн даатгал	13,401,700.00	12,430,947.00	970,753.00	92.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,763,300.00	43,763,300.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,543,300.00	10,848,856.00	- 1,305,556.00	113.68
210302	Түлш, халаалт	32,240,000.00	32,864,444.00	- 624,444.00	101.94
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	50,000.00	1,930,000.00	2.53
2104	Хангамж, бараа материалын зардал	7,876,300.00	7,876,300.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	545,400.00	461,800.00	83,600.00	84.67
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	372,700.00	492,200.00	- 119,500.00	132.06
210404	Ном, хэвлэл	410,000.00	410,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,500.00	191,200.00	229,300.00	45.47
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,127,700.00	2,321,100.00	- 193,400.00	109.09
2105	Норматив зардал	42,794,100.00	42,794,100.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,339,400.00	14,339,400.00	-	100.00

Архангай аймгийн Чулуунт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	24,234,300.00	24,234,300.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,220,400.00	4,220,400.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,283,900.00	8,283,900.00	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,483,900.00	7,483,900.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,981,700.00	4,981,700.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,981,700.00	4,981,700.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,548,400.00	26,885,783.00	2,662,617.00	90.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,548,400.00	26,885,783.00	2,662,617.00	90.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,998,400.00	25,335,783.00	2,662,617.00	90.49
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,550,000.00	1,550,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	966,758,300.00	961,100,021.00	5,658,279.00	99.41
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	922,995,000.00	917,336,721.00	5,658,279.00	99.39
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	922,995,000.00	917,336,721.00	5,658,279.00	99.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,763,300.00	43,763,300.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	43,763,300.00	43,763,300.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64	62	2	97
620001	Удирдах ажилтан	3	3	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	39	38	1	97
620003	Үйлчлэх ажилтан	22	21	1	95
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	720	720	-	100
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	720	720	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	743,400.00	5,460,249.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743,400.00	5,460,249.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	743,400.00	5,460,249.09
2104	Хангамж, бараа материалын зардал	743,400.00	755,449.09
210401	Бичиг хэрэг	743,400.00	755,449.09
2105	Норматив зардал		252,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	252,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,716,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,716,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,735,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,735,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	743,400.00	8,648,249.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	743,400.00	8,648,249.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	648,249.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	8,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, шилэн дансны хууль, 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа, аудиторын туслах Ц.Аюушжав нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ж.Ням-Осор, Захирал Д.Баатарсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Чулуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймаг Чулуут сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хичээл сургалтын үйл ажиллагааг эрүүл аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн танхимын болон цахим хэлбэрээр тасралтгүй, чанартай зохион явуулж, суралцагчийг сурлагаар хоцрогдох, хичээл завсардахаас сэргийлэн, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж, багш өөрийн мэргэжлээр тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналт шалгалтын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хичээл сургалт, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөдөлмөрийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүү аж ахуйн үйл ажиллагааны өнөөгийн байдалд хяналт шалгалт хийж ажилсан байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чулуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Батлагдсан төсөв”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг батлагдсан төсөв 966.8 сая төгрөгийн 1 хувь буюу 9.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89.2 сая төгрөгөөр буюу 10.26 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан өөрчлөлт байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	78.3	89.9	11.6
Үндсэн хөрөнгө	791.1	868.7	77.6
Нийт хөрөнгө	869.4	958.5	89.2
Өр төлбөр	0	0.5	0.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	869.4	958.0	88.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	869.4	958.5	89.2

3.5.1. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 14.8 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 78.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 122.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 110.9 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 89.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 9,8 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 791.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 109,9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны элэгдэл 35.9 сая төгрөгөөр нэмэгдэж 868.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Өр төлбөр данс нь 0.5 сая төгрөгөөр өссөн ба энэ нь түлш халаалтын өглөг байна.

3.5.4. Цэвэр хөрөнгө өмчийн дүн 89.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө нөлөөлсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	923.5	923.0	- 0.5
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	52.5	43.8	- 8.8
Туслах үйл ажиллагааны орлого			-
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.7	8.6	7.9

Архангай аймгийн Чулуунт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	43.5		- 43.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал			-
Үйл ажиллагааны орлого	1,020.2	975.4	- 44.8
Цалин, шимтгэлийн зардал	820.8	826.5	5.7
Бараа үйлчилгээний зардал	81.0	92.4	11.4
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3.2	2.3	- 0.9
Бараа үйлчилгээний бусад зардал	48.2	44.3	- 3.8
Урсгал шилжүүлэг	66.4	32.5	- 33.9
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз			-
Үйл ажиллагааны зардал	1,019.6	998.0	- 21.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	0.7	-22.6	- 21.5

Тус сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 8.8 сая төгрөг буюу 16.7 хувиар буурсан нь эмчийн батлагдсан орон тоон дээр ажилтан аваагүйтэй холбоотой санхүүжилт буурсан байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 966.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 966.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 966.8 сая төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 966.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 961.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 961.1 сая төгрөг буюу 99.41 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 8.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт төвлөрүүлсэн байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мөн 2021 онд тус байгууллага нь “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, хичээл сургалтын үйл ажиллагааны явцад халдвараас сэргийлэх дэглэмийг сахиулахтай холбоотой сургууль орчмын бүс, сургалтын байр анги танхимд 2 цаг тутам цэвэрлэгээ, 5 хоногт 1 удаа ариутгал хийж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.3 хувь байна.

- Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан нийт 966.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 961.1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.41 хувь байна.

- Авлигатай тэмцэх газарт иргэнээс гаргасан гомдлын дагуу Чулуунт сумын ЕБС-ийн 2021 оны сурагчдын үдийн цай, хоолны зардлын худалдан авах ажиллагааг аймгийн Төрийн аудитын газраас шалгажээ. Шалгалтаар 17.9 сая төгрөгийн материалыг шууд худалдан авсан зөрчил илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Тус сургууль өндөр насны тэтгэвэрт тогтоолгож чөлөөлөгдсөн 2 ажилтны орон тоон дээр нөхөн томилгоо хийсэн байна.

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2.Суудлын автомашин ашиглалтын хувьд: УАЗ 220695 маркийн 61-88 АРХ улсын дугаартай 2019 онд үйлдвэрлэгдсэн 33.6 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахууны зардалд 5.8 сая төгрөгийг төсөвлөж, 4.0 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 86 мэдээллээс 80 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчлүүд илрэв. Үүнд:

1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн 2 ажилтны орон тоон дээр нөхөн томилгоо хийж 4.9 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.2-д Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх гэснийг хэрэгжүүлээгүй 4.9 сая төгрөгийн зардал гаргасан тул албан шаардлага хүргүүлж байна.

2. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтын хүрээнд төсвийн хасагдах тодотгол хийснээр тус байгууллага нь гүйцэтгэлээр 107.7 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тогтоолын хүрээнд 10.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд "Батлагдсан төсөвт зардлын дүнд 10-с доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй 10.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй тул албан шаардлага хүргүүлэв.

3. Тус байгууллага нь тогтмол зардалд /гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус/ 43.8 сая төгрөг батлуулж, гүйцэтгэлээр 43.8 мянган төгрөгийн зардал гаргаж, 8.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаагүй ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8-д заасан тогтмол зардалд 20-ис доошгүй хувийн хэмнэлт гаргах гэсэн заалтыг мөрдөөгүйд албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ .

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитаар нийт 49.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шилэн дансны хугацаа хоцроосны зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 49.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлт бүрэн хэрэгжсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, түүний зарцуулалтыг шалгах.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 0.5 сая төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд бүрэн залруулсан тул албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй болно.

Залруулагдаагүй алдаа, зөрчил илрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Цалингийн зардлыг цалингийн өглөг дансаар дамжуулан бүртгэсэн 0.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрэв.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 14-р зүйл, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 0.5 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан тухай 2022 оны 2 дугаар сарын 17-ний өдрийн №05 албан тоот ирүүлж санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Ерөнхий боловсролын лаборатори Нэгдүгээр сургууль	1	0.5	1	0.5	0	0	0	0	0	0
Дүн		1	0.5	1	0.5	0	0	0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Ерөнхий боловсролын лаборатори Нэгдүгээр сургууль	4	24.5	0	0	0	0	4	24.5	0	0
Дүн		4	24.5	0	0	0	0	4	24.5	0	0
Нийт дүн		5	24.5	1	0.5	0	0	4	24.5	0	0